



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандеш баг  
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93  
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn  
Вэбсайт: www.audit.mn

2021. 03. 15 № 01/384  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН  
САНГИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
Э.ДАВААЧУЛУУН ТАНАА

**Удирдлагад хүргэх захидал**

Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 8 дугаар зүйлийн 8.1, 6 дугаар зүйлийн 6.3.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам"-ын 5.3.2- т заасны дагуу Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанд Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийж гүйцэтгэв.

Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланд бие даасан санал дүгнэлт гаргалгүй, үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж аудитын дүнг дээд шатны байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын дүнд оруулж тайлагнана.

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн.

Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамжид горим сорилуудыг гүйцэтгэж аудитын дүнг дэмжих нотлох зүйлсийг цуглуулсан.

**Үүрэг, хариуцлага**

Төсөв захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитаар Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэхэд дараах алдаа зөрчил илэрсэн болно. Үүнд:

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр нягтлан бодогч Ч.Цэнгэлд 2,163,228 төгрөгийн үр чадварын нэмэгдэл, жижүүр Н.Шинэбаатарт 1,121,778 төгрөгийн хавсран ажилласан нэмэгдэл, хүчин төгөлдөр бус захиргааны актаар захирлаар ажиллаж байсан Н.Оюунтуяад 666,596 төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон байна. Зөрчилд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба төлбөрийн акт тогтоосон байна.

2. Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 оны 12 дугаар сард өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг ханган ажиллах, албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг баримтлан ажиллах.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

О.ГАНБОЛД